

БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2017 оны 11-р сарын 01-ний өдөр Дугаар 2017 1204 163 Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г

Нэг талаас: Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "Түрээслэгч тал" гэх/, түүнийг төлөөлж Төслийн ажлын хэсгийн дарга, Ч. Баттулга

Нөгөө талаас: Дижитал медик ХХК /цаашид "Түрээслүүлэгч тал" гэх/ түүнийг төлөөлж Баттулгын Төгс-Эрдэнэ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээ нь Эх хүүхдийн эрүүл мэндийн болон эмч нарын гарын авлагын програм хангамжийн IOS хувилбарыг боловсруулахад шаардагдах iMac компьютерийг түрээслэх, түрээслүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулах, тэдгээрийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 2.1. Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1-д заасан ажлыг 2017 оны 11-р сарын 01-ний өдрөөс 2018 оны 01-р сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.
- 2.2. Дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - а.Талууд харилцан тохиролцсоноор,
 - б.Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачлагаар

ГУРАВ. ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨР

- 3.1. Түрээсийн зүйлийн нэг сарын төлбөрийг 1.080.000 /нэг сая наян мянга/-н төгрөгөөр тогтоов.
- 3.2. Гэрээ байгуулагдсан өдөр түрээсийн зүйлийн төлбөрийг 3 сараар буюу 3.564.000 /гурван сая таван зуун жаран дөрвөн мянга/-н төгрөгийг Гүйцэтгэгч талын Хаан банкны 5009753054 тоот дансанд шилжүүлнэ. /энэхүү төлбөрт НӨАТ-ийн дүн орсон болно/

ДӨРӨВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. Түрээслүүлэгчийн цагийн хуваарьт захирагдахгүйгээр үйл ажиллагаагаа явуулах ба програм хангамжтай холбоотой аливаа асуудлыг цаг тухайд нь засварлуулах эрхтэй.
- 4.2. Түрээсийн компьютерийг зориулалтын дагуу ариг гамтай, цэвэр, бүрэн бүтэн байдлыг хангаж ашиглана.
- 4.3. Түрээслэг өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах эрхтэй.

ТАВ. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1. Түргээслэгч тал түрээсийн төлбөрөө тохирсон хугацаанаас хожимдуулсан тохиолдолд хожимдсон хоног тутамд сарын төлбөрийн 0.5 хувийн алданги тооцох эрхтэй.
- 5.2. Түрээслүүлэгч түрээсийн компьютерийн хэвийн ажиллагааг хариуцна.
- 5.3. Түрээслүүлэгч түрээсийн гэрээг цуцлах зайлшгүй шаардлагатай бол гэрээг цуцлахаас 1 сарын өмнө нөгөө талдаа мэдэгдэх үүрэгтэй.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 6.1. Гэрээний үүрэг хэрэгжих явцад Талуудын хамтын ажиллагааны ёс зүйг эрхэмлэн байгууллагын нэр хүнд болон түүнд хамаарах бусад үнэт зүйлсийг хүндэтгэж ажиллана.
- 6.2. Талууд хамтын ажиллагааны явцад олж авсан нууцад хамаарах аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар хортойгоор буруугаар ашиглах болон гуравдагч этгээдэд задруулахыг хатуу хориглоно.
- 6.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүтнээр нь биелүүлээгүй, санаатай болон санамсаргүй үйлдсэн буруутай үйл ажиллагаанаас нөгөө талдаа учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас захиалагч буюу гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгэх боломжгүй болбол нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгана.

НАЙМ. БАТАЛГАА

- 8.1. Гэрээний дагуу талуудаас гаргаж өгсөн болон гаргаж өгөх бүх баримт бичиг, мэдээлэл, баталгаа нь үнэн зөв бөгөөд гэрээ хүчин төгөлдөр болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал нөхцөл байдлыг орхигдуулаагүй.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. Гэрээтэй холбогдон үүсэх аливаа маргаантай асуудлыг талууд эв зүйгээр зохицуулахыг эрмэлзэх бөгөөд ингэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1. Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

10.2. Гэрээ нь адил хүчинтэй хоёр хувь үйлдэгдсэн бөгөөд Талууд тус бүрт нэг нэг хувь хадгалагдана. Талууд гэрээг хувилж тараахыг хориглоно.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТҮРЭЭСЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨСЛИЙН АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА


Ч. БАТТУРИГА

УХАА 456 9056001

ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Б.ТӨГС-ЭРДЭНЭ